ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2012 оны 12 сарын 07 өдөр Дугаар 169 Мандалговь

Хөрөнгө актлах тухай.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77,3 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит" хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 3 дугаар зүйлийн 3,1 дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Боловсрол Соёлын газрын барилгын өргөтгөл хийхдээ холбогдуулж авто граж, складыг актлуулахаар ирүүлсэн тус төвийн санал МХБайцаагчийн дүгнэлтийг зөвшөөрч акталсугай.

2. Дээрхи авто гражи, складыг данснаас хасахыг аймгийн Боловсрол Соёлын газар /Ц.Сэрээнов/-д зөвшөөрсүгэй.

3. Актлах хөрөнгөд хяналт тавихыг Өмчийн албанд үүрэг болгосугай.

ДАРГА Ц.МӨНГӨНЦООЖ

0100000784

My doc.alban bichig.togtool

ДУНДГОВЬ АЙМГИЙН
БОЛОВСРОЛ СОЁЛЫН ГАЗАР
48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг

2012·11·15 № 130

танай ____________-ны № ____________-т

АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДЭД

Боловсрол, соёлын газрын өргөтгөлийн барилга баригдахтай холбогдуулан авто граж, склад болгон ашиглаж байгаа зуухны барилгыг буулгах шаардлага гарсан юм. Энэ барилга нь хуучин материалаар баригдаад олон жил ашигласан тул өөр газар шилжүүлэн барих боломжгүй болсон байна.

Иймд Төрийн өмчийн хорооны "Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын ажлыг зохион байгуулах тухай 2012 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолын дагуу гражи 2ш, складыг /зуухны барилга/ МХГ-ын Улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн хөрөнгийн бүртгэлээс хасах, актлах саналыг хүргүүлж байна.

Хүлээн авч шийдвэрлэж өгөхийг хүсье.

ДАРГА Ц.СЭРЭЭНОВ

60

0000-2227

Боловсрол соёлын газрын актлах хөрөнгийн жагсаалт

| Нэр төрөл | Ашиглалтанд орсон он | Тоо хэмжээ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|---|---|---|---|---|---|
| Граж | 1996 | 2 | 693 | 172.7 | 520.3 |
| Склад | 1996 | 1 | 19521.6 | 4864.1 | 14657.5 |
| | | | | | 15177.8 |

Акталсан хөрөнгийг худалдах үнийн санал

| Нэр төрөл | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Балансын үнэ | Худалдах үнийн санал |
|---|---|---|---|---|
| Граж | 2 | 7328.75 | 14657.5 | 500 |
| Склад | 1 | 520.3 | 520.3 | 100 |
| | | | 15177.8 | 600 |

Тооцоолол:

Тус байгууллагын граж склад нь аж ахуйн аргаар хуучин байшин

| Нэр төрөл | Тоо хэмжээ | нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Ачиж буулгах зардал |
|---|---|---|---|---|
| Тоосго | | 200 | 200 | 4 хүн тус бүр 50.0 төгрөг 200.0 |
| Хавтан | 8 | 100 | 800 | кран 1 цаг-100.0 |
| Хаалга | 2 | 100 | 200 | хог ачсан машины хөлс 5 удаа тус бүр 60.0 төгрөг 300.0 |
| Дүн | | | 1200 | Нийт гарсан зардал-600 |

Тооцоо бодсон эдийн засагч Б.Мягмарсүрэн

ДУНДГОВЬ АЙМГИЙН
БОЛОВСРОЛ СОЁЛЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг
Утас/Факс: 70593028
E-mail: ssia_p_du@chinggis.com
www.inspection.gov.mn

2012.10.12 № 13-07-016/218

Барилгын төлөв байдлын тухай

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 7-р багийн нутаг дэвсгэрт байршилтай Боловсрол Соёлын Газрын автограж, складын барилгын төлөв байдлыг 2012 оны 09-р сарын 28–нд аймгийн МХГ-ын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Г.Тулга үзэж танилцлаа.

Уг авто граж, складын барилга нь 1996 онд бетон суурь, тоосгон хана, төмөр бетон хучилттай, хар цаасан дээвэртэй аж ахуйн аргаар баригдаж ашиглалтанд орсон байна.

Одоогийн байдлаар дээврийн руберiодон хучилга муудаж ус нэвчдэгээс дотор талын шавардлага ховхорсон, өрөгийн чанар муугаас хананд ан цав үүссэж дулаан алдагдал их болсон нь цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон байна.

Дээрхи байдлаас үндэслэн ДҮГНЭЛТ болгох нь:

1. Иймд БСГазрын автограж, складын барилгыг ашиглалтаас хасах нь зүйтэй гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Г.ТУЛГА

УЛСЫН БАЙЦААГЧ 13-07-016

69